



**“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөгөөг баталсан:

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Тэмдэг



Төсвийн Ерөнхийлөн захирагч

/С.Амарсайхан/

2025.08.27

(огноо)

Төлөвлөгөөг боловсруулсан:

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ

(албан тушаал)

Тэмдэг



Төсвийн шууд захирагч

/Д.Дамдинцэрэн/

2025.06.24

(огноо)

АГУУЛГА

| | |
|--|----|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ..... | 3 |
| 1.1.СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ | 3 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ..... | 4 |
| 2.1.“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2020-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ | |
| 2.2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ | 8 |
| 2.3.“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ..... | 11 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. “ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ | |
| | 15 |
| 3.1. АЛСЫН ХАРАА..... | 15 |
| 3.2.ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ЗОРИЛГУУД..... | 15 |
| 3.3.“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН СТРАТЕГИ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ | |
| ТӨЛӨВЛӨГӨӨ | 16 |
| 3.4.СТРАТЕГИ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 19 |
| 3.5 “ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ | |
| АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ..... | 26 |
| ХАВСРАЛТ 1 “ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ | |
| 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН. | |
| ХАВСРАЛТ 2 ДОТООД, ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХОЛБОГДОХ | |
| МАТЕРИАЛ. | |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого", Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Чөлөөт бүсийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны шинэтгэлийн бодлогын баримт бичиг, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, чөлөөт бүсийн хөгжлийн бодлогын бичиг баримт зэрэгт тулгуурлан байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны хэтийн төлөв, хүрэх үр дүнг төсөөлж, асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэгтэй уялдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Аргачлал, загвар батлах тухай 100 дугаар тушаалын дагуу "Замын-Үүд" чөлөөт бүсийн стратеги төлөвлөгөөг боловсруулсан болно.

"Замын-Үүд" чөлөөт бүсийн стратеги төлөвлөгөөний зорилтууд нь урьд хэрэгжүүлж ирсэн бодлого, хөтөлбөр, түүний үйл ажиллагааны зорилтуудтай нягт уялдаж, тэдгээрийн шууд үргэлжлэл болон дэвшигдэж байгаагийн зэрэгцээ цаг үеийн шаардлагаар гарч ирсэн шинэ зорилтуудаар баяжигдсан төлөвлөгөөг зохих хууль, дүрмийн дагуу боловсруулагдсан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: "ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

2.1."ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2020-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.17.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.

3.1.19.Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулна.

| Д.Д | Зорилт | Арга хэмжээ |
|---|---|--|
| 1 | 2.11.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана; | "Замын-Үүд" чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн 2-р эзлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх. |
| "Замын-Үүд" чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар эзлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх арга хэмжээний хүрээнд: | | |
| <ul style="list-style-type: none"> ➢ "Замын-Үүд" чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг 2008 онд "Нийслэлийн хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэн" боловсруулж, 2011 онд Засгийн газрын 187 дугаар тогтоолоор батлагдсан. Уг мастер төлөвлөгөө нь Нийгэм эдийн засгийн болон цаг үеийн нөхцөл байдал, чөлөөт бүсэд төлөвлөгдсөн суурьшлын бүсэд дахин төлөвлөлт хийх, Монгол, Хятад хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах бодлоготой уялдуулан мастер төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, тодотгох шаардлага үүссэн. ➢ "Замын-Үүд" чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд өөрчлөлт, тодотгол оруулах ажлыг хэрэгжүүлэхээр МУ-ын Шадар сайдын 2019 оны 1 сарын 17-ны өдрийн 07 дугаар тушаалаар "Азийн хөгжлийн банкны бүс нутгийн хамтын ажиллагаа болон интеграцийн төслүүдийг бэлтгэхэд зориулсан техникийн туслалцааны төслийн хүрээнд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. ➢ Шадар сайд Ө.Энхтүвшин, БХБЯ-ны сайд Х.Баделхан нар 2020 оны 3 сарын 2-ны өдрийн 2020/05 дугаар тушаалаар "Замын-Үүд" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /тодотгол/, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг баталсан. ➢ ТГТ ХХК-ийн боловсруулсан "Замын-Үүд" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /тодотгол/, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авсан. | | |
| 2 | 2.11.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана; | Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах асуудлыг судлах ажлын хүрээнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналтын механизмыг тодорхой болгох. |

Монгол Улс, БНХАУ хооронд эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах асуудлыг судлах ажлын хүрээнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналтын механизмыг тодорхой болгох арга хэмжээний хүрээнд:

- Шадар сайдын ажлын алба, хууль зүй, дотоод хэргийн яам хамтран судалгаа хийсэн. Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-ийг Засгийн газраар дэмжигдэж, Улсын Их хуралд өргөн барьсан.
- Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2022 оны 12 сарын 09 өдөр Монгол Улсын Их Хурлаар батлуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтад "Замын-Үүд" чөлөөт бүстэй холбоотой үндэсний дэд хөтөлбөр:

1. Эдийн засгийн сэргээх хөтөлбөр, түүний нарийвчилсан төлөвлөгөө

| Д/Д | Зорилт | Арга хэмжээ | Төлөвлөгөө |
|-----|---|--|---|
| 1 | 2.1. Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх үндэс суурийг тавих | 2.1.2 Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх, хил орчмын төрийн байгууллага хоорондын уялдааг хангаж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах; | 2.1.2.2.Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эхлүүлэх. |

Эдийн засгийн сэргээх хөтөлбөр, түүний нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилт

- Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 02 сарын 13-ны өдрийн 11 тоот тушаалаар хууль эрх зүйн орчин, хяналтын механизмыг судалж санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг, хил дамнасан чөлөөт бүс байгуулснаар Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судалж санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэг, хил дамнасан чөлөөт бүсийн дэд бүтэц, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн талаар санал дүгнэлт гаргах үүрэг бүхий 3 дэд ажлын хэсгийн байгуулсан.
- Ажлын хэсгүүдийн гаргасан санал дүгнэлтүүдийг нэгтгэн төсөл боловсруулж Монгол Хятадын хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны зэргэлдээх бүсүүдийн бүтээн байгуулалтын хоёр талын засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах хэлэлцээний явцыг түргэтгэх тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын Худалдааны яам хооронд 2018 оны 4-р сарын 8-ны өдөр Санамж бичиг байгуулсан.
- 2019 оны 3 сарын 11, 12-ны өдрүүдэд "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн Газар хоорондын хэлэлцээр"-ийн төслийг Хятадын талтай хэлэлцэн тохиролцохоор Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Л.Саянаагаар ахлуулсан баг "Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төслийг үзэглэсэн.
- 2019 оны 6 сарын 4-нд хоёр улсын Засгийн газрын төлөвлөл "Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурсан.
- Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Их хурлаар соёрхон батлуулсан.

- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 280 дугаар тогтоолоор Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүнийг баталсан.
- Монгол Улсын Гадаад харилцааны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/69 дүгээр тушаалгаар Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан.
- Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүний хуралдааныг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр, 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр тус тус зохион байгуулсан.
- 2023.07.04-ний өдөр зохион байгуулсан Хамтын ажиллагааны бүсийн хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүнд танилцуулан "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөг БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулахыг дэмжсэн.
- Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Захирагчийн 2023 оны А/08 дугаар захирамжаар байгуулан, хурлыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав.
- 2023.09.07-ны өдөр ӨМӨЗО-ны Эрээн хотын намын хорооны орлогч дарга, "Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагч нар хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагаа бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх талаар санал солилцож цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хамтран ажиллах санамж бичиг байгуулав.
- Хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаарыг Захирагчийн ажлын албанаас боловсруулан 2023.12.15-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нар баталсан.
- "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээр"-т тусгасан гурван түвшний удирдлагын механизм болох Хамтарсан гүйцэтгэх болон хамтарсан менежментийн зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүнийг Гадаад харилцааны Сайдын А/51, А/74 дүгээр тушаалуудаар тус тус байгуулагдсан.
- 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын шинэчилсэн бүрэлдэхүүний хурлыг зохион байгуулж, бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, холбогдох байгууллагуудад Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн монгол талын дарга чиглэл өгч ажиллав.
- 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдааныг БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх Хотод зохион байгуулсан.
- Гадаад харилцааны сайдын 2024.11.22-ны А/75 тушаалаар Хамтын ажиллагааны бүсийн гол гарцын хил огтлон гарах цэгийн байршлыг тогтоох ажлын хэсэг байгуулагдаж, хилийн цэг дээр ажиллах товийг тохирох саналыг БНХАУ-ын талд ноот бичиг хүргүүлсэн.

2. Талын зам үндэсний хөтөлбөр:

| № | Зорилт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа |
|---|--|---|
| 1 | Чөлөөт бүс, хилийн боомтуудад хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлж, хил орчмын бүс нутгуудыг хөгжүүлэн хот, суурин газруудыг шинээр байгуулна. | 3.4.2. "Замын-Үүд" чөлөөт бүсийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх; |
| "Замын-Үүд" чөлөөт бүсийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт | | |

- Монгол Улсын засгийн газар, Азийн хөгжлийн банктэй /АХБ/ хамтран "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн 30 сая ам.долларын санхүүжилт бүхий зээлийн хэлэлцээрт АХБ-ны Монгол Улсыг хариуцсан захирал Павит Рамачандран, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин нар 2020 оны 06 сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан.
- Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкны энгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл" нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, бүс нутгийн хөгжлийг түргэсгэх, хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх үйл явцыг "Замын-Үүд" чөлөөт бүсийн дэд бүтэц бүхий 300 га талбайд төвлөрсөн байдлаар хэрэгжих юм. Энэхүү төслийн хүрээнд чөлөөт бүсийн дэд бүтэц, түүнд шаардагдах байгууламжуудыг шинээр барьж байгуулах, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангах болон чөлөөт бүсийн оновчтой менежментэд чиглэгдсэн үйл ажиллагаанууд хэрэгжинэ.
- Монгол Улсын Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 221 дугаартай тушаалаар "Төсөл хэрэгжүүлэх нэгж" байгуулагдсан.
- Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 89 дугаар тушаалаар Төслийн удирдах хороог байгуулсан.
- Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Төслийн удирдах хороог шинэчлэн байгуулсан.
- "Замын-Үүд" чөлөөт бүсийн ачаа тээврийн гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар"-ыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/16 дугаар; "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хүрээнд баригдах "Замын-Үүд" чөлөөт бүсийн энгийн болон ахуйн хог хаягдлыг шилжүүлэх, хог хаягдал ангилах, дахин боловсруулах зориулалттай төвийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар"-ыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/17 дугаар; "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хүрээнд баригдах "Замын-Үүд" чөлөөт бүсийн зорчигч тээврийн гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар"-ыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/18 дугаар олгон баталгаажуулж төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх компанид хүргүүлснээр гэрээний хэрэгжилт хэвийн хангагдах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.
- Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн бүрэлдэхүүн 2 буюу "Чөлөөт бүсийн менежментийн зөвлөх компани" багц ажлын явцын 1, 2, 3 тайлантай танилцаж, санал дүгнэлт боловсруулан, захиалагч талд хүргүүлэн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

| № | Бодлогын зорилт | Хариуцсан ажил | Биелэлт |
|---|---|----------------|---------|
| 1 | Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 1 | 80% |
| 2 | Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ | 2 | 80% |
| 3 | Үндэсний хөтөлбөр | 2 | 100% |
| 4 | Гурван тулгуурт хөгжлийн бодлого | 1 | 100% |
| | Нийт | 6 | 90% |

2.2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 18 |
|--|--|--|
| Үүнээс: | Тухайн салбарын хуулийн тоо | 1 |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 17 |
| <p>Ерөнхий чиг үүрэг-1: Монгол Улсыг бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, оролцоог нэмэгдүүлж чөлөөт бүсүүдийг хөрш орнуудын төлөвлөлттэй уялдуулж, бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн бүсийн эдийн засаг, худалдааны хэрэгцээ шаардлагад үндэслэн чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгээр хөгжүүлнэ.</p> | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| <p>ҮЧҮ-1: "Замын-Үүд" чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх.</p> | <p>"Замын-Үүд" чөлөөт бүсийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангах бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p> | <p>-Шадар сайдын ажлын алба; -Хөрөнгө оруулалтын зөвлөл; -Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүд.</p> |
| | <p>Аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалтын үр ашиг, эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт хийх;</p> | |
| | <p>Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй хамтран ажиллах;</p> | |
| | <p>Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх;</p> | |

| | | |
|--|--|---|
| <p>ҮЧҮ-2: "Замын-Үүд" чөлөөт бүсэд тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дэд бүтцийг хөгжүүлэх;</p> | <p>"Замын-Үүд" чөлөөт бүсийн төлөвлөлтийн хүрээнд газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах, дэд бүтцийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах;</p> | <p>- Шадар сайдын ажлын алба; -Хот байгуулалт,барилга,орон сууцжуулалтын яам; -Барилгын хөгжлийн төв; -Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар; -Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар.</p> |
| | <p>"Замын-Үүд" чөлөөт бүсийн дэд бүтцийн хүчин чадалд суурилагдсан бүтээн байгуулалтын ажилд шаардагдах техникийн нөхцөл болон архитектор төлөвлөлтийн даалгавар, төслийн санал боловсруулж батлуулах;</p> | |
| | <p>Чөлөөт бүсийг орчин үеийн өндөр технологитой дэд бүтцийн эх үүсвэрийн нэгдсэн дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын байгууламжийг цогцоор нь шийдвэрлэх;</p> | |
| | <p>Үйлдвэрлэл, үйлчилгээний ил тод байдал, тэдгээрийн зарчим, стандартууд болон байгаль орчинд халгүй дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх;</p> | |
| <p>ҮЧҮ-3: "Замын-Үүд" чөлөөт бүсийн газар зохион байгуулалт, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах</p> | <p>Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын мөнлайллыг хангах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлагнах;</p> | <p>- Шадар сайдын ажлын алба; -Авлигатай тэмцэх газар; -Төрийн албаны зөвлөл; -Удирдлагын академи.</p> |
| | <p>Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх явцад эрх зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах талаар хяналт-шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж гаргах;</p> | |
| | <p>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын гомдлын мөрөөр</p> | |

| | | |
|---|---|--|
| | <p>дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх;</p> <p>Дээд байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээ, тайланг гаргах;</p> | |
| <p>ҮЧҮ-4 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, мэдээллийн технологийн найдвартай байдлыг хангах;</p> | <p>Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг сурталчлах, холбогдох санал гаргах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх, найдвартай ажиллагааг хангах;</p> <p>Хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд болон олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийн үндэслэлийг боловсруулах, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, хэрэгжилтийг хангах;</p> <p>Салбарын мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэх, сургах, даван бэлтгэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах;</p> | <p>- Шадар сайдын ажлын алба;</p> <p>-Гадаад харилцааны яам;</p> <p>-Дата төв;</p> <p>-Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд;</p> <p>-Вэб хөгжүүлэгч компани.</p> |
| <p>ҮЧҮ-5 “Замын-Үүд” чөлөөт бүсийн бүртгэл санхүү, төсвийн удирдлагыг хангах;</p> | <p>“Замын-Үүд” чөлөөт бүсийн санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн зохион байгуулах, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах;</p> <p>Гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлтэй холбоотой хураамж төлбөр тооцоог зохих журмын дагуу бүрдүүлэх, тайлагнах;</p> <p>Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, тоног төхөөрөмж, худалдан авах үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах;</p> <p>“Замын-Үүд” чөлөөт бүсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт,</p> | <p>- Шадар сайдын ажлын алба;</p> <p>-Сангийн яам;</p> <p>-Үндэсний аудитын газар;</p> <p>-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар;</p> <p>-Улсын бүртгэлийн газар.</p> |

| | | |
|--|---|--|
| | хамгаалалтын хяналтыг үнэн зөв гүйцэтгэх; | |
|--|---|--|

2.3.“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

“Замын-Үүд” чөлөөт бүсийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг дор дурдсан байдлаар тодорхойлж байна.

| Гадаад орчны нөлөөлөл: | Дотоод орчны нөлөөлөл |
|--|--|
| <p>Эдийн засгийн орчин:</p> <ul style="list-style-type: none"> Улсын төсвийн байдал Монгол Улсын Шадар сайдын багцын төсөв Олон улсаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэмжээ <p>Техник технологийн орчин:</p> <ul style="list-style-type: none"> Мэдээллийн технологи Орчин үеийн дэвшилтэд техник, технологийн хөгжил Судалгаа шинжилгээний үр дүн <p>Улс төрийн орчин:</p> <ul style="list-style-type: none"> Сонгуулийн үр дүн Засгийн газрын харьяа бүтэц <p>Эрх зүйн орчин:</p> <ul style="list-style-type: none"> Хууль, тогтоомж. Бодлого, хөтөлбөр <p>Хэрэглэгч:</p> <ul style="list-style-type: none"> Төрийн болон төрийн бус байгууллага Иргэд аж ахуйн нэгжүүд <p>Түншлэгч:</p> <ul style="list-style-type: none"> Төрийн болон төрийн бус байгууллага Олон улсын байгууллага Иргэд, Хөрөнгө оруулалтын зөвлөл | <p>Бүтэц, зохион байгуулалт:</p> <ul style="list-style-type: none"> “Замын-Үүд” чөлөөт бүсийн бүтэц, зохион байгуулалт Албан тушаалын тодорхойлолт <p>Дотоод дүрэм, журам:</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагын дотоод журам Албаны дүрэм Байгууллагын соёл <p>Хүний нөөц:</p> <ul style="list-style-type: none"> Нөхөн хангалт Ажиллагсдын мэргэжил, боловсрол, мэдлэг, ур чадвар, хандлага Хамт олны уур амьсгал Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд Сургалт, хөгжил Удирдлагын арга барил <p>Техник, технологи:</p> <ul style="list-style-type: none"> Техник, технологийн ашиглалт, судалгаа, шинжилгээ <p>Ажлын байрны нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> Ажлын байрны байршил Ажлын байрны тохижилт, эрүүл ахуй <p>Санхүү:</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагын санхүүгийн чадавх Орлогын эх үүсвэр Өр, авлага Төсвийн захиран зарцуулалт |

“Замын-Үүд” чөлөөт бүс нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түргэн шуурхай хүргэхийн тулд бүхий л нөөц, боломжоо зориулж ажиллана. Байгууллагын үйл ажиллагаанд болон энэхүү стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дээрх гадаад, дотоод орчин ихээхэн нөлөөтэй тул түүнийг байнга хянаж, сайжруулах бодлого баримтална. Үүнд:

Гадаад орчны нөлөөлөлд:

- Эдийн засгийн орчинд зохицож үйл ажиллагаагаа явуулах, төсөв, санхүүгээ сайжруулах бүхий л бололцоог эрэлхийлэх.

- Орчин үеийн дэвшилтэд, техник, технологийн хөгжлөөс аль болох хоцрохгүй байх.
- Улс төрөөс аль болох хамаарал багатай байх.
- Хууль, эрх зүйн орчинг аль болох сайжруулах, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах.
- Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хөрөнгө оруулагч нарын хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлогыг баримтална.

Дотоод орчны нөлөөлөлд:

- Бүтэц, зохион байгуулалтаа аль болох оновчтой, боловсронгуй болгох.
- Дотоод дүрэм журмаа нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгох, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг сайжруулж, хадгалах.
- Хүний нөөцийг чадваржуулах, тэдний нийгмийн баталгааг хангах, удирдлагын арга барил, манлайллыг дээшлүүлж, сургалт, хөгжлийг эрхэмлэх.
- Техник, технологийн шинэчлэл, ашиглалт, судалгаа, шинжилгээний үр нөлөөг дээшлүүлэх, шинэ мэдлэг, санал, санаачилгыг дэмжих.
- Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуйг дотоод нөөц боломждоо тулгуурлан сайжруулах.
- Байгууллагын санхүүгийн чадавхыг сайжруулах, хадгалах, шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг байнга эрэлхийлэх, өр авлагагүй ажиллах, төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр дүнтэй захиран зарцуулах, илт тод байдлыг хангах.
- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд тасралтгүй сурталчлан таниулах, мэдээллийг ил тод нээлттэй байлгах.
- Нэгжийн үйл ажиллагаа, ажлын уялдааг сайжруулах, бие биенээсээ тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэх.
- Сахилга хариуцлагыг дээшлүүлэх, албан хаагчдын үр дүнтэй ажиллах, урамшууллын механизмыг бий болгох бодлого баримтална.

Байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээг SWOT шинжилгээний аргаар хийж, өнөөгийн дүр төрхийг тодорхойлов.

1. Гадаад орчны шинжилгээ

| Боломж | Бэрхшээл |
|--|---|
| 1. Эдийн засгийн орчин | |
| Газар зүйн байршлын хувьд давуу талтай. <ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн асуудлууд шийдэгдсэн. • Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлнэ. • Чөлөөт бүсэд валют болон гадаад гүйлгээгээр давуу эрх эдэлнэ. • Ажлын байр, орлого бий болно. • Экспортын өсөлт нэмэгдэж, бараа бүтээгдэхүүний төрөлжилт бий болно. • Гадаад шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. • Үйлчилгээний бизнесийн боломжуудыг бий болгох, өргөжүүлэх. | <ul style="list-style-type: none"> • Улс орны эдийн засгийн чадавх сул тул төсвийн хөрөнгө мөнгө хязгаарлагдмал. • Төрийн эдийн засгийн бодлогоос хамааралтай тул эдийн засгийн нөөцийн баталгаа, тогтвортой найдвартай байдал сул. • Эдийн засгийн байдлаас шалтгаалж, батлагдсан бодлого, хөтөлбөр хагас дутуу хэрэгжих. |

| | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Гадаад улс, орны ижил төстэй чөлөөт бүсүүдийн туршлага. • Түүхий эдийг БНХАУ-аас хямд авч нэмүү өртөг шингээх замаар үйлдвэрлэлийг хөгжүүлэх. • Валютын чөлөөт хөрвөлтийг хангаж, нөөцийг нэмэгдүүлэх • Газрын нөөц ихтэй • Зах зээлийн багтаамж сайтай орнуудтай хил залгадаг. • "Замын-Үүд" чөлөөт бүс нь Монгол Улсын хөгжлийн гарц болох боломжтой. • БНХАУ-ын экспортлогчдын нийлүүлэлтийн сүлжээг ашиглан дэлхийн экспортын зах зээлд нэвтрэх боломжийг олж авах. | <ul style="list-style-type: none"> • Хүн ам цөөн, үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн. • Усны эх үүсвэрийн нөөц багатай. |
| 2. Техник, технологийн орчин | |
| <ul style="list-style-type: none"> • Орчин үеийн шинэ техник, технологи, мэдээллийн технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. • Судалгаа шинжилгээний үр нөлөөг дээшлүүлж, олон улсын жишигт хүргэх, аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах. • Төсөл, хөтөлбөр - хэрэгжүүлэх замаар дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. | <ul style="list-style-type: none"> • Төсвөөс шалтгаалан шинэ техник, технологийг нэвтрүүлэх боломж бага, хүрэлцээ муу, ихэнх хувь нь хуучирч муудсан. |
| 3. Улс төрийн орчин | |
| <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг тул аливаа асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэхэд шат дамжлага бага гардаг. • Улс төрөөс хараат байдлыг багасгах, төрийн албаны тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах. | <ul style="list-style-type: none"> • Хэт их төрийн оролцоо хяналттай. • Байгууллагын удирдлага улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж ойр ойрхон солигдох магадлал өндөр. • Улс төрийн нөлөөлөл, удирдлагын арга барилаас шалтгаалж хүний нөөцийн бодлого, тогтвор суурьшил алдагдах. |
| 4. Эрх зүйн орчин | |
| <ul style="list-style-type: none"> • Чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчинг сайжруулах, боловсронгуй болгох. | <ul style="list-style-type: none"> • Хууль, эрх зүйн орчин өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон. |

2. Дотоод орчны шинжилгээ

| | |
|------------------|----------------|
| Давуу тал | Сул тал |
|------------------|----------------|

| 1. Бүтэц, зохион байгуулалт | |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> • Аж үйлдвэрийн сайдын тушаалаар зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлагдаж, газар, нэгжийн чиг үүрэг тодорхой болсон. • Байгууллагын чиг үүргийн шинжилгээг "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу хийж албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулсан. • Албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал бүрт хийсэн. | <ul style="list-style-type: none"> • Орон тооны дээд хязгаарыг Засгийн газраас баталдаг учраас шаардлагатай орон тоог нэмэх боломжгүй. |
| 2. Хүний нөөц | |
| <ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн нөхөн хангалт тодорхой хэмжээнд хийгдэж мэргэжлийн боловсон хүчнээр зохих түвшинд хангагдсан. | <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн мэдлэг ур чадвартай боловсон хүчний дутмаг байдал. • Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийн түвшин бага, тэдний сурж хөгжих хүсэл эрмэлзэл, идэвх сул • Өндөр боловсролтой, мэдлэг чадвартай боловсон хүчин шинээр ажилд орох магадлал бага. |
| 3. Техник, технологи | |
| | <ul style="list-style-type: none"> • Техник, тоног төхөөрөмж хангалт хүрэлцдэггүй. • Төсвөөс шалтгаалан шаардлагатай техник, тоног төхөөрөмж, худалдан авч чаддаггүй. |
| 4. Ажлын байрны нөхцөл | |
| <ul style="list-style-type: none"> • Ажлын байрны байршил сайтай. • Ажлын байрны шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр зохих түвшинд хангагдсан. | <ul style="list-style-type: none"> • Ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах. • Ажлын байрны техник төхөөрөмж хангалтгүй. • Төсөв, санхүүгийн нөхцөлөөс шалтгаалж, албан хаагчдын нийгмийн баталгаа сул. |
| 5. Санхүү | |
| <ul style="list-style-type: none"> • Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилт шийдэгддэг. • Өр, авлага харьцангуй бага. • Төсвийн захиран зарцуулалт нээлттэй. | <ul style="list-style-type: none"> • Байгууллагын үйл ажиллагаа улсын төсвөөс хамааралтай тул батлагдсан төсөв хүрэлцдэггүй, үүнээс шалтгаалж зарим төлөвлөсөн ажил тасалдах, дутуу биелэх зэрэг сөрөг нөлөө гардаг. |

ГУРАВДУГААР БҮЛЭГ. "ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ



Алсын Хараа



Эрхэм Зорилго



Стратеги Зорилгууд

3.1. АЛСЫН ХАРАА

Олон улсын жишигт нийцсэн, дэвшилтэт технологи, инновацид суурилсан, байгаль орчинд ээлтэй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс" болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

"Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийг хөгжүүлж, Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.

3.2. ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ЗОРИЛГУУД

1. Чөлөөт бүсийн стратегийн зорилтыг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, бодлого боловсруулах, удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;
2. Чөлөөт бүсэд дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, чөлөөт бүсэд газар ашиглуулахтай холбогдсон харилцааг зохион байгуулах;
3. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чөлөөт бүсийн болон холбогдох бусад хууль тогтоомжуудад нийцүүлэн эрх зүйн акт, гэрээ журам, төсөл хөтөлбөрийг хянах, хяналт-шинжилгээ, аудит хийх, чөлөөт бүсийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, тэднийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг бүрдүүлэх, чадавхыг сайжруулах, ажлын үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж, дүгнэх;
4. Чөлөөт бүсийг хөгжүүлэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;
5. Чөлөөт бүсийн санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө, төсвийг үр ашигтай зарцуулж, чөлөөт бүсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих;

3.3. "ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН СТРАТЕГИ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратегийн зорилго тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

- Чөлөөт бүсийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангах бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;
- Аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалтын үр ашиг, эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт хийх;
- Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй хамтран ажиллах;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхыг сайжруулах, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх;

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- Чөлөөт бүсийн төлөвлөлтийн хүрээнд газар ашиглуулах ажлыг зохион байгуулах, дэд бүтцийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах;
- Чөлөөт бүсийн дэд бүтцийн хүчин чадалд суурилагдсан бүтээн байгуулалтын ажилд шаардагдах техникийн нөхцөл болон архитектор төлөвлөлтийн даалгавар, төслийн санал боловсруулж батлуулах;
- Чөлөөт бүсийг орчин үеийн өндөр технологитой дэд бүтцийн эх үүсвэрийн нэгдсэн дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын байгууламжийг цогцоор нь шийдвэрлэх;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний ил тод байдал, тэдгээрийн зарчим, стандартууд болон байгаль орчинд халгүй дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх.

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

- Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлагнах;
- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх явцад эрх зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах талаар хяналт-шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж гаргах;
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- Дээд байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээ, тайланг гаргах.

Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг сурталчлах, холбогдох санал гаргах, дэмжлэг үзүүлэх;
- Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх, найдвартай ажиллагааг хангах;
- Хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд болон олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийн үндэслэлийг боловсруулах, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, хэрэгжилтийг хангах;
- Салбарын мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан бэлтгэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах.

Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

- Чөлөөт бүсийн санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн зохион байгуулах, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлтэй холбоотой хураамж төлбөр тооцоог зохих журмын дагуу бүрдүүлэх, тайлагнах;
- Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, тоног төхөөрөмж, худалдан авах үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах;
- Чөлөөт бүсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын, хяналтыг үнэн зөв гүйцэтгэх.

Чөлөөт бүсийн үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, бүтцийн нэгжүүд болон ажилтнуудын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан ажиллана.

Гуравдугаар бүлэг. "Замын-Үүд" чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө

3.4. СТРАТЕГИ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба/

| Д/д | Стратеги, зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | | | Хариуцагч | | Санхүүжилтийн эх үүсвэр | |
|---|---|-------------------------------|-------------|--------------|--------|-----------------|------|------|------|-----------|---------|-------------------------|---------------------------|
| | | | | он | түвшин | 2025 | 2026 | 2027 | 2028 | Үндсэн | Хамтран | | |
| <p>Ерөнхий чиг үүрэг. Монгол Улсыг бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, оролцоог нэмэгдүүлж чөлөөт бүсүүдийг хөрш орнуудын төлөвлөлттэй уялдуулж, бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн бүсийн эдийн засаг, худалдааны хэрэгцээ шаардлагад үндэслэн чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгөөр хөгжүүлнэ.</p> <p>Зорилт 1 Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ.</p> | | | | | | | | | | | | | |
| 1 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зам, инженерийн сүлжээ дэд бүтцийн байгууламжуудыг барьж дуусгах. | Гүйцэтгэл | хувь | 2024 | 30% | 50% | 60% | 60% | 80% | 100% | ЗҮЧБ | ШСАА | ТХХТ Улсын төсөв |
| 2 | АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийг үргэлжлүүлэх. | Төслийн хэрэгжилт | хувь | 2024 | 11.5% | 30% | 50% | 80% | 100% | 100% | ЗҮЧБ | ШСАА | Гадаадын зээл, тусламж |
